

ТУСГАЙ ХЭРЭГСЭЛ ҮЙЛДВЭРЛЭХ, ЗАСВАРЛАХ, УЛСЫН ХИЛЭЭР НЭВТРҮҮЛЭХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Цагдаагийн төв байгууллагын даргын зөвшөөрөлтэй хуулийн этгээд тусгай хэрэгсэл үйлдвэрлэх, засварлах, улсын хилээр нэвтрүүлэхэд Цагдаагийн албаны тухай хууль, Гаалийн тухай хууль, Засгийн газрын 2002 оны 219 дүгээр тогтоол болон бусад хууль тогтоомж, энэхүү журмыг баримтална.

1.2.Хууль зүй, дотоод хэргийн сайдын баталсан “Тусгай техник, хэрэгсэл, галт зэвсэг, сумны жагсаалт”-д тусгагдсан тусгай хэрэгслийг үйлдвэрлэх, дуурайлган хийх ба улсын хилээр импортлоно.

1.3.Энэ журамд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

“Хуулийн этгээд” - өмчлөлдөө буюу эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхдээ тусгайлсан хөрөнгөтэй, өөрийн нэрээр эрх олж, үүрэг хүлээдэг, үйл ажиллагаанаасаа бий болох үр дагаврыг эд хөрөнгөөрөө хариуцдаг, нэхэмжлэгч, хариуцагч байж чадах, тодорхой зорилго бүхий, тогтвортой үйл ажиллагаа эрхэлдэг зохион байгуулалтын нэгдлийг;

“Тусгай хэрэгсэл” – нэг бүр /гав, хүлэг, ороох цамц, хөдөлгөөн хязгаарлах бусад хэрэгсэл, бороохой, цахилгаан гүйдлээр цохигч, нулимс асгаруулагч, амьсгал боогдуулагчаар цэнэглэсэн буу, шүршүүр, резин болон хуванцар сумтай буу, нэг бүрийн бусад тусгай хэрэгсэл/-ийн болон олон хүнд нөлөөлөх нулимс асгаруулагч, амьсгал боогдуулагч, усан хөөрөг, утаан хөшиг үүсгэгч, бусад тусгай хэрэгсэл, тээврийн хэрэгсэл албадан зогсоох тусгай хэрэгслийг.

Хоёр. Зөвшөөрөл олгох, хяналт тавих

2.1.Цагдаагийн төв байгууллагын Лицензийн төв тусгай хэрэгсэл үйлдвэрлэх, засварлах, импортлох үйл ажиллагаа эрхлэх хүсэлт гаргасан иргэн, хуулийн этгээдээс дараах баримт, бичгийг хүлээн авна:

а/өргөдөл /тусгай хэрэгсэл үйлдвэрлэх, засварлах, импортлох/;

б/хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний эх хувь, нотариатаар гэрчлүүлсэн хуулбар;

г/улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт.

2.2.Хүсэлт гаргасан иргэн, хуулийн этгээдийн бүрдүүлсэн материалыг хүлээн авснаас хойш зөвшөөрөл олгох эсэхийг 21 хоногийн дотор судалж, шаардлага хангасан тохиолдолд олгоно.

2.3.Энэ журмын 2.1-д заасан материал бүрдүүлэлтийн шаардлага хангаагүйн улмаас хүсэлт гаргасан хуулийн этгээдэд зөвшөөрөл өгөхөөс татгалзах бол үндэслэлийг зааж, албан бичгээр хариу өгнө.

2.4.Лицензийн төв болон нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын хэв журам хариуцсан нэгжийн ахлах байцаагч тусгай хэрэгсэл үйлдвэрлэх, засварлах, импортлох үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл авсан хуулийн этгээдийн үйл ажиллагаанд хяналт тавьж, сан бүрдүүлнэ.

2.5.Тусгай хэрэгсэл үйлдвэрлэх, засварлах, импортлох үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл авсан хуулийн этгээдийн үйл ажиллагаанд хяналт тавихад хэсгийн төлөөлөгч, байцаагч байнгын дэмжлэг үзүүлэх үүрэгтэй.

Гурав.Зөвшөөрөл олгох, сунгах

3.1.Цагдаагийн төв байгууллагын дарга тусгай хэрэгсэл үйлдвэрлэх, дуурайлган хийх, импортлох иргэн, хуулийн этгээдэд зөвшөөрөл олгоно.

3.2.Бүртгэлд авч, зөвшөөрлийн гэрчилгээ /цаашид “Гэрчилгээ” гэх/-г олгосноор тусгай хэрэгсэл үйлдвэрлэх, засварлах, импортлох үйл ажиллагаа эрхлэх эрх үүснэ.

3.3.Гэрчилгээний хугацааг сунгахад тухайн хуулийн этгээдийн бүтэн жилийн ажлын тайлан, үйлдвэрлэсэн, засварласан, импортолсон болон худалдсан тусгай хэрэгслийн мэдээ, бусад шаардагатай баримт бичгийг үндэслэж 3 хүртэл жилээр сунгана.

3.4.Хуулийн этгээд нь гэрчилгээний хугацаа дуусахаас 21 хоногийн өмнө хугацааг сунгуулах хүсэлтээ Улаанбаатар хотод бол Лицензийн төвд, аймагт бол нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагад гаргана.

3.5.Нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллага иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн гэрчилгээ авах, сунгуулах хүсэлтийг судалж, Лицензийн төвд ажлын 2 хоногийн дотор хүргүүлнэ.

3.6.Лицензийн төв гэрчилгээг сунгах эсэх шийдвэрийг хүсэлт, материал хүлээн авсанаас хойш 3 хоногийн дотор шийдвэрлэнэ.

Дөрөв.Зөвшөөрлийг хүчингүй болгох, хяналт тавих

4.1.Тусгай хэрэгсэл үйлдвэрлэх, засварлах, импортлох гэрчилгээг Лицензийн төв нь дараах тохиолдолд хүчингүй болгож, албан бичгээр мэдэгдэнэ:

а/хуулийн этгээдийн удирдлага, ажилтнаас удаа дараа гэмт хэрэг, зөрчил гаргасан, зөрчлийг нуун дарагдуулсан, тухайн зөрчилд арга хэмжээ аваагүй;

б/хуулийн этгээд нь өөрөө хүсэлт гаргасан, хуулийн этгээд татан буугдсан, үйл ажиллагаатай нь холбогдуулан цагдаагийн болон бусад эрх бүхий төрийн байгууллагаас тавьсан шаардлагыг удаа дараа биелүүлээгүй;

в/гэрчилгээг хүчингүй болгосон тухай шийдвэрийн талаар шийдвэр гарснаас хойш 3 хоногийн дотор гэрчилгээ эзэмшигч хуулийн этгээд, харьяалах татварын албанд албан бичгээр мэдэгдэнэ.

4.2.Тагнуул, Цагдаа, Гаалийн байгууллага тусгай хэрэгсэл үйлдвэрлэх, засварлах, импортлох хуулийн этгээдийн үйл ажиллагаанд хяналт тавина.

4.3.Шаардлагатай тохиолдолд тусгай хэрэгсэл үйлдвэрлэх, засварлах, импортлох үйл ажиллагаа эрхэлж буй иргэн, хуулийн этгээдийн үйл ажиллагааг иж бүрэн буюу хэсэгчилсэн байдлаар шалгаж болно.

Тав.Тусгай хэрэгсэл үйлдвэрлэх, дуурайлган хийхэд тавигдах шаардлага

5.1.Тусгай хэрэгсэл нь техникийн норм, дүрэм, стандарт, аюулгүй байдлын шаардлагыг бүрэн хангасан байх бөгөөд шинжлэх ухааны холбогдох байгууллагын дүгнэлт, үйлдвэрлэгчийн тодорхойлолтоор баталгаажсан байна.

5.2.Импортоор оруулах тусгай хэрэгсэл нь үйлдвэрлэгч улсын стандарт, техникийн норм, дүрэм, аюулгүй байдлын шаардлагыг бүрэн хангасан, үйлдвэрлэгчийн техникийн тодорхойлолтоор баталгаажсан байна.

5.3.Ашиглахыг хориглосон тусгай хэрэгсэл, түний бүрэлдэхүүн хэсэг, нэмэлт тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгслийг импортоор оруулахыг хориглоно.

Зургаа.Тусгай хэрэгсэлд үйлчилгээ, засвар хийх, түүний аюулгүй байдлыг хангах шаардлага

6.1.Тусгай хэрэгсэлд хийсэн техникийн засвар, үйлчилгээ нь аюулгүй байдлын шаардлагыг бүрэн хангасан байна.

6.2.Засвар, үйлчилгээг хийхдээ үйлдвэрлэгчээс тогтоосон техникийн норм, дүрэм, зааварчилгааг мөрдлөг болгоно.

6.3.Засвар, үйлчилгээ хийсэн хуулийн этгээд тусгай хэрэгслийн техникийн үзүүлэлт, аюулгүй байдлын шаардлагад бүрэн нийцэж байгааг зохих баримт бичгээр баталгаажуулна.

Долоо.Тусгай хэрэгсэл хилээр нэвтрүүлэхэд хийх гаалийн шалгалт

7.1.Цагдаагийн төв байгууллагын Лицензийн төв нь улсын хилээр галт зэвсэг нэвтрүүлэх хүсэлтийг хүлээн авч, ажлын 5 хоногийн дотор судалж, шийдвэрлэнэ.

7.2.Тусгай хэрэгсэл хилээр нэвтрүүлэх зөвшөөрөл авсан хуулийн этгээд нь гаалийн мэдүүлгийг холбогдох хууль, тогтоомжид заасны дагуу тухайн байгууллагад шаардагдах бичиг баримтын хамт бүрдүүлсэн байна.

7.3.Гаалийн газар, хороо нь мэдүүлгийг холбогдох бичиг баримтын хамт хүлээн авч, гаалийн хууль тогтоомжийн дагуу бичиг баримт болон бараанд шалгалт хийж, тусгай хэрэгслийг Монгол Улсын нутаг дэвсгэрт оруулах эсэхийг шийдвэрлэнэ.

7.4.Хилээр нэвтрүүлсэн тусгай хэрэгслийн зөвшөөрөлд гаалийн байгууллага тэмдэглэл хийж, гаалийн мэдүүлэгт хавсаргаж үлдээнэ.

7.5.Гаалийн байгууллага “Тусгай хэрэгслийг улсын хилээр оруулсан мэдээ”-г гаалийн удирдах төв байгууллагын гаалийн хяналт шалгалт хариуцсан нэгжид сар бүрийн 30-ны өдрийн дотор ирүүлнэ.

7.6.Гаалийн хяналт шалгалт хариуцсан нэгж нь мэдээг нэгтгэн дараа сарын 5-ны өдрийн дотор цагдаагийн төв байгууллагын зөвшөөрөл олгосон нэгжид хүргүүлнэ.

7.7.Гаалийн хууль тогтоомжийн зөрчлийн улмаас хураагдсан болон нягтлан шалгах зорилгоор саатуулагдсан тусгай хэрэгслийг гаалийн удирдах төв байгууллагад хүргүүлж цагдаагийн байгууллагад мэдээллийг хүргүүлнэ.

Найм. Бусад

8.1.Тусгай хэрэгслийг бусдаар дамжуулан улсын хилээр нэвтрүүлэхийг хориглоно.

8.2.Цагдаагийн төв байгууллагын холбогдох нэгж нь улсын хилээр нэвтрүүлэх тусгай хэрэгслийг “Тусгай техник, хэрэгсэл, галт зэвсэг, сумны жагсаалт”-д орсон эсэхэд хяналт тавьж ажиллана.

----oOo----

МОНГОЛ УЛС
ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР

УЛСЫН ХИЛЭЭР ТУСГАЙ ХЭРЭГСЛИЙГ
НЭВТРҮҮЛЭХ ЗӨВШӨӨРӨЛ

20....оны ... сарын ...-ны өдөр

Дугаар

Аймаг, нийслэл.....

Зөвшөөрөл авсан аж ахуйн нэгж, байгууллага, иргэний регистр, хаяг, утасны дугаар	
Тусгай хэрэгслийн төрөл <i>/өмнөх дугуйг тэмдэглэх/</i>	<ul style="list-style-type: none"> ○ нэг бүрийн; ○ олон хүнд нөлөөлөх; ○ тээврийн хэрэгсэл албадан зогсоох; ○ бусад.
Тусгай хэрэгслийн нэр, тоо, хэмжээ	
Зориулалт	
Хүлээн авагчийн хаяг	
Улсын хилээр нэвтрүүлэх боомтын нэр, тээврийн хэрэгслийн төрөл	
Улсын хилээр нэвтрүүлэх он, сар, өдөр	

Зөвшөөрөл олгосон:

Цагдаагийн ерөнхий газрын Лицензийн төвийн дарга.....

Гаалийн бүрдүүлэлт хийсэн он, сар, өдөр

Гаалийн мэдүүлгийн дугаар
/гаалийн улсын байцаагчийн нэр/

.....он....сарын ...-ны өдөр

----oOo----